

**ПАРА ЖУДО БӨХИЙН 2017 ОНЫ  
МОНГОЛ УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ VII ДАХЬ ТЭМЦЭЭН**

Спорт Төв Ордон, А заал 2017/ 04/09

Батлав:



Х.Цагаанбаатар /Монголын Паралимпийн Жүдо  
Бөхийн Холбооны Ерөнхийлөгч

**ЗААВАР**

**Зорилго:**

Монгол улсад Пара жүдо бөхийг хөгжүүлэх, жүдо бөхөөр хичээллэх дур сонирхол бий болгох, жүдо бөхийн гайхамшигт ёс суртахуун, дэг жаяг, уран мэх техникийг сурах боломж олгох улмаар бие бялдрын болон оюун санааны өв тэгш хүмүүжил олгох, пара жүдо бөхийн спортыг нийтийн хүртээл болгон сурталчлахад гол зорилго оршино.

**Зохион байгуулах байгууллага:**

Монголын Паралимпийн хороо, Монголын Паралимпийн Жүдо Бөхийн Холбоо, Монголын Жүдо Бөхийн Холбоо, утас/факс: 9191-3303, 9975-2338, 8888-5888, 9000-9991, 8009-8999

**Тэмцээн зохиогдох хугацаа, газар:**

Улаанбаатар хот, Спортын төв ордны А заал, 2017оны 04 сарын 08-09

**Оролцогчдын жингийн ангилал :**

Эрэгтэй: -60кг, -66кг, -73кг, -81кг, -90кг, -100кг, +100кг

Эмэгтэй: -48кг, -52кг, -57кг, -63кг, -70кг, +70кг ангилалаар явагдана.

Тэмцээнийг Жүдо бөхийн Олон Улсын дүрмээр зохион явуулна.

**Бүртгэл, мандат олголт**

2017 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Монголын Паралимпийн хорооны өрөөнд явагдана. Тэмцээнд оролцох байгууллагуудын мэдүүлгийг 04 сарын 08-ны өдөр хүлээн авч мандат олгоно. Жин тус бүрд 1 байгууллагаас оролцох тамирчдын тоог харгалзахгүй.

Бүртгэлд дараах зүйл шаардлагатай: Багийн албан ёсны мэдүүлэг, тамирчны цахим үнэмлэх, 3.5х4.5 хэмжээтэй 1% зураг. Тэмцээнд хараагүй болон харааны бэрхшээлтэй / **B1, B2, B3**/ ангилалын тамирчид оролцоно. Нүдний хараа нь 70%-иас дээш, эмчийн бичигтэй, группийн дэвтэртэй ирнэ., Мандатын хураамж 10.000төгрөг.

Тэмцээний зохион байгуулалт, явагдах дүрэм, журамтай холбогдсон санал, хүсэлтээ дасгалжуулагчид техникийн зөвлөгөөний хурал дээр илэрхийлэх бөгөөд тэмцээнд оролцож буй бүх багийн дасгалжуулагчид хуралд оролцоно. Сугалаа гар аргаар татна.

#### ***Техникийн зөвлөлгөөний хурал, сугалаа***

2017 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр болно. Тус хурлын дараа үргэлжлэн сугалаа явагдана. Сугалаа компьютерийн программ дээр хийгдэх бөгөөд 1 байгууллагын 2 тамирчныг хэсгээс салгаж сугална.

#### ***Шүүлт, зохион байгуулалт***

Тэмцээнийг Монголын Жүдо Бөхийн Холбооны Шүүгчийн зөвлөлөөс томилогдсон Олон улсын болон улсын шүүгчид, спорт, техникийн ажилтанууд удирдан явуулна.

#### ***Жүдоги болон ёслолын хувцас***

Тамирчид цагаан, цэнхэр өнгийн жүдогитой барилдах бөгөөд тэмцээний нээлт, шагнал гардуулах ёслолын ажиллагаанд зөвхөн цагаан өнгийн жүдогитой оролцоно. Нээлтийн болон шагнал гардуулах ёслолын ажиллагаанд оролцох албаны хүмүүс ёслолын хувцастай байх бөгөөд дасгалжуулагчид шигшээ барилдаанд ёслолын хувцастай тамирчнаа дасгалжуулна.

#### ***Дүн гаргах, шагнал олгох журам***

Байгууллагын дүнг эрэгтэй, эмэгтэй баг тус бүрээр медалийн чанараар гаргана. 1,2,3 дугаар байр эзэлсэн багийн дасгалжуулагчдад цом, медаль, өргөмжлөлөөр шагнана. Жин тус бүрт 1,2,3 дугаар байр эзэлсэн тамирчдад медаль, өргөмжлөлөөр шагнана.

#### ***Ёслолын ажиллагаа***

Тэмцээний нээлтийн ёслолын ажиллагаа 2017 оны 04 дүгээр сарын 09-ны 13.00 цагт болно. Шагнал гардуулах болон хаалтын ёслолын ажиллагаанд тамирчид, шүүгчид идэвхитэй оролцоно.

***Жич:*** Орон нутгийн тамирчдын ирж, очих замын зардал болон байр, хоолны зардлыг үндсэн байгууллага нь хариуцна.

## ТЭМЦЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

2017 оны 04 дүгээр сарын 08 /Бямба гариг/

- 10.00-14.00 Бүртгэл, мандат олгох  
/Спортын Төв ордон, Монголын Паралимпийн өрөө 25 тоот
- 14.00-16.00 Техникийн зөвлөлгөөний хурал, сугалаа /Спортын Төв ордон
- 16.00-16.30 Албан бус хяналтын жин ажиллана.
- 17.00-17.30 Албан ёсны жин үзнэ.  
Эрэгтэй: -60кг, -66кг, -73кг, -81кг, -90кг, -100кг, +100кг  
Эмэгтэй: -48кг, -52кг, -57кг, -63кг, -70кг, +70кг

2017 оны 04 дүгээр сарын 09 /Ням гариг/

- 10.00-13.00 Тэмцээн эхэлж урьдчилсан барилдаан явагдана.
- 13.00-14.00 Тэмцээний нээлтийн ёслолын ажиллагаа
- 14.00-16.00 Хагас шигшээ, шигшээ барилдаан
- 16.00 Шагнал гардуулах болон хаалтын ёслолын ажиллагаа

